



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

“Багануур” хувьцаат компанийн 2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалтыг зөрчиж 4,885.8 сая төгрөгийн найдваргүй авлага үүсгэсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 19, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж 4,402.8 сая төгрөгийн худалдан авалт хийсэн зэрэг нийт 9,288.6 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур” хувьцаат компанийн 2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Багануур” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Э.Номинчулуунд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2. Компанийн хөрөнгийг зохистой удирдаж, авлага, өглөгийг бууруулж ажиллах, нэг жилээс дээш хугацаатай авлагыг шүүхийн журмаар нэхэмжлэх;

2.3. Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөр аудитын байгууллагыг сонгох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох асуудлыг хэлэлцүүлж байх;

2.4. Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцүүлэн улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн талбай дээр Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн даргын 2006 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 1071 дүгээр шийдвэрээр Төв аймгийн Баяндэлгэр сум, Баруун хонхор нэртэй 1791 гектар талбайд 12164Х дугаар гэрчилгээ бүхий хайгуулын, Кадастрын бүртгэлийн төвийн даргын 2007 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 2375 дугаар шийдвэрээр Төв аймгийн Баяндэлгэр сумын Баруун хонхор нэртэй газарт 1182 гектар талбайд 12959А дугаар гэрчилгээ бүхий ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатайгаар “Алтай голд” ХХК-д олгож, “Алтай голд” ХХК-иас ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Алтай гянт” ХХК-д шилжүүлсэн маргаатай асуудлыг холбогдох хууль хяналтын байгууллагад тавих;

2.5. “Эрдэнэс Монгол” ХХК болон “Багануур” ХК-ийн хооронд байгуулсан Менежментийн үйлчилгээний төлбөрийн гэрээний үр дүн, ажлын тайлан, өр төлбөрийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх;

0000279

2.6.Охин компани болох “Багануур илч” ХХК алдагдалтай ажиллаж, найдваргүй авлага, өр төлбөр үүсгэж байгааг харгалзан үзэж компанийн үйл ажиллагааг үр ашигтай болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, асуудлыг “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

2.7.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
144... дугаар тогтоолын хавсралт

“Багануур” хувьцаат компанийн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Зөрчлийн дүн /Сая төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх хэсэгт заасныг зөрчиж найдваргүй авлага үүсгэсэн	Гүйцэтгэх захирал, Санхүү, эдийн засаг эрхэлсэн дэд захирал, Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс	4,885.8	Харилцагчтай байгуусан гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах, найдваргүй авлага үүсгэхгүй байх
2	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 19, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал, Худалдаа хангамжийн хэлтэс	4,402.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр нээлттэй ил тод зарлаж, журмын дагуу зохион байгуулж, тогтоосон хугацаанд тайлан гаргаж байх
Зөрчил, дутагдлын нийт дүн			9,288.6	